



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 6/09

Бэрх хот

Б.Одыг ажилд томилох тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 05/9317 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын Соёлын ордны захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Болдбаатарын Одыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Болдбаатарын Одын албан тушаалын цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ТҮСБ-5 зэрэглэлийн 1.637.000 (нэг сая зургаан зуун гучин долоо мянган) төгрөг, Орон нутагт ажилласны нэмэгдэл 40 хувь, бусад нэмэгдлийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу бодож олгохыг соёлын ордны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Соёлын ордны захирлаар томилогдсон Б.Одыг Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө оруулгын мэдүүлгээ гаргаж өгөхийг сануулсугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН